



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.03.14-2022.03.18



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.03.21-ний after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	34,754.93	-0.32%	5.18%	3.14%	5.86%
US500	4,451.21	-0.27%	6.70%	3.44%	13.00%
NASDAQ	14,377.00	-0.30%	10.21%	3.66%	9.87%
Европ					
GB100	7,405.00	0.26%	3.48%	-1.06%	10.37%
DE40	14,413.00	0.17%	5.76%	-2.16%	-1.42%
FR40	6,620.00	0.12%	5.75%	-2.48%	10.37%
IT40	24,222.00	0.41%	5.13%	-7.02%	0.09%
ES35	8,418.00	0.07%	3.38%	-0.84%	-0.89%
Ази					
JP225	26,827.00	0.65%	6.62%	-0.31%	-9.95%
SHANGHAI	3,264.00	0.39%	1.15%	-5.69%	-5.31%
CSI 300	4,284.00	0.41%	2.54%	-6.41%	-15.35%
SHANGHAI 50	2,906.00	-0.26%	1.88%	-6.35%	-17.89%
CH50	13,808.62	0.12%	3.33%	-6.92%	-19.97%
SENSEX	57,864.00	1.84%	4.33%	0.05%	17.57%
Эрчим хүч					
Газрын тос (Crude Oil)	107.66	2.83%	4.52%	17.15%	74.90%
Газрын тос (Brent)	110.78	2.64%	3.63%	14.39%	71.43%
Байгалийн хий	4.93	1.34%	5.80%	10.47%	90.86%
Шатахуун	3.30	1.88%	4.12%	21.72%	68.36%
Нүүрс	334.50	-0.82%	-9.26%	43.04%	260.65%
Түүхий эд					
Алт	1,926.29	0.27%	-1.28%	1.48%	10.79%
Мөнгө	25.08	0.51%	0.24%	4.11%	-2.71%
Зэс	4.67	-0.81%	3.55%	3.59%	12.62%
Бонд /10 жил/ Өгөөж					
АНУ	2.15	0.0000	0.16%	0.21%	0.42%
Англи	1.50	0.0660	0.01%	0.10%	0.66%
Швейцар	0.39	0.0160	0.03%	0.15%	0.71%
Испани	1.34	0.0040	0.06%	0.13%	0.96%
Португали	1.19	0.0350	0.05%	0.06%	0.95%


Эх сурвалж: Trading economics



СЕКЮРИТИЗ
ҮЦК



Утас: 7707-8181 7707-8282



Эх сурвалж: Business Insider

АНУ-ЫН БОДЛОГЫН ХҮҮ ӨССӨНТЭЙ ХОЛБООТОЙ МЭДҮҮШТЭЙ 5 ЗҮЙЛ


Холбооны Нөөцийн Сан (ХНС) 2018 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ нэмж 0.5% болгов. ХНС нь бодлогын хүүгээ 2023 он гэхэд 2.8% болгох төлөвлөгөөтэй байна.

1. ХНС инфляцын түвшинг зорилтод хэмжээнд аваачих бодлоготой ажиллаж байна.

Инфляцын түвшин АНУ-д 7.9% хүрч сүүлийн 40 жилд үзэгдээгүй дээд хэмжээнд очсон нь ХНС-г бодлогын хүүг өсгөж хатуу мөнгөний бодлого баримтлахаас өөр аргагүйд хүргэсэн.

ХНС-ийн хүсэж байгаа зүйл бол нийлүүлэлтийг сайжруулж инфляцын түвшинг барихад байгаа хэдий ч хэзээ сайжрахыг таамаглашгүй тул бодлогын хүүг шат дараалалтай өсгөхөөр ажиллаж байна. Ингэснээр ирэх 2 жилд зээлийн хүү өсөж эргэлтэд байгаа мөнгөний хэмжээг багасгаснаар инфляцыг тогтворжуулна гэж үзэж байна.

АНУ-ын бодлогын хүү ба инфляцын түвшин



Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- ХНС-аас энэ жил бодлогын хүүг 7 удаа өсгөж, 2023 онд 4 удаа, 2024 онд өсгөхгүй байх төлөвлөгөөтэй байна. Энэ нь бодлогын хүүг энэ жил 1.9%, 2023 он гэхэд 2.8% болгохоор байна.

Өнгөрсөн 7 хоногт ХНС чанга мөнгөний бодлого баримтлахаа мэдэгдсэн ба ХНС-ийн санхүүгийн тайлан дээрх 9 их наяд долларын бондын үлдэгдлийг энэ 5 сараас эхлэн зарж бууруулах төлөвлөгөөтэй байна.

Бодлогын хүүг өсгөсөн удаа



Эх сурвалж: www.edwardjones.com

- Шинжээчдийн үзэж байгаагаар эдийн засгийг сэргээхэд бодлогын хүүг өсгөх шаардлага бага харагдаж байна.

Түүхий эдийн үнийн өсөлт болон Орос-Украины дайны хямралаас үүдэлтэй хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа ч эдийн засгийн өсөлт энэ жил дунджаас илүү байх таамагтай байна. ХНС-ийн төсөөллөөр ДНБ 2022 онд 2.8% өсөх төлөвтэй байна. Энэ үзүүлэлт нь 3 сарын өмнө хийсэн төсөөллөөс бага ч сүүлийн 10 жилийн дундаж болох 2%-иас илүү байна.

Суурь нөхцөл байдлыг авч үзэхэд, ажилгүйдлийн түвшин 3.8% байгаа нь түүхэн доод хэмжээ ба шинээр бий болж байгаа ажлын байрны тоо ажилгүй болсон иргэдийн тооноос ойрын 20 жилд байгаагүйгээр илүү үзүүлэлттэй гарсан. Энэ нь ажлын байр нэмэгдэж байгааг харуулж байгаа ба цаашид үргэлжлэн сайжрах төлөвтэй байгааг харуулж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ажлын байр нэмэгдсэнээр өрхийн орлого, хуримтлал нэмэгдэж өр төлбөр буурна. Энэ бүхэн худалдан авагчдын санхүүгийн нөхцөл байдлыг ойрын хэдэн жилд үзэгдээгүйгээр сэргэхийг харуулж байна.

Шинээр бий болсон ажлын байрны тоо ба ажилгүй болсон иргэдийн тоо /сая хүн/



4. ХНС нь ирэх 3 жилийн дотор эдийн засгийн өсөлтөө хэт багасгалгүйгээр инфляцын түвшнийг 2%-д хүргэх зорилготой. Түүхээс авч үзэхэд энэ зорилгод хүрэх хүндрэлтэй ба бодлогын хүүг өсгөснөөс дунджаар 2.5 жилийн дараа эдийн засгийн хямрал болдог таагүй статистиктай. 2023 онд эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас бага байвал 2024 онд хөрөнгийн зах зээл өсөхөд хүндрэлтэй байж магадгүй.

ХНС-ийн мөнгөний бодлого хэт хатуу байгаа эсэхийг тодорхойлоход 10 жил, 3 сарын хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөжийн зөрүү сөрөг болсон эсэхийг анхаардаг. Хэрвээ энэ хоёр үнэт цаасны өгөөжийн зөрүү сөрөг болбол эдийн засгийн хямрал болоход ойртож байгааг дохидог.

Эх сурвалж: www.edwardjones.com

5. Түүхээс харахад хатуу мөнгөний бодлого баримталсан үед хувьцаа болон бондын зах зээлийн өгөөж эерэг байжээ.

1985 оноос хойш 5 удаагийн хатуу мөнгөний бодлого баримталсан ба тухайн үед хөрөнгийн зах зээлийн өсөлт эхний бодлогын хүүг өсгөснөөс хойш хагас жилийн дараа эерэг болжээ.


Европ

Орос-Украины дайн Европт хамгийн хүндээр нөлөөлж байгаа билээ. Ирэх 7 хоногт Европын 3 сарын PMI үйлдвэрийн индексийн мэдээ гарсны дараа нөхцөл байдал ямар байгааг харж болно.

Газрын тосны ханш өссөнтэй холбоотой эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь үйлдвэрлэлийг бууруулж, PMI индексийг доош нь татах хүчин зүйл болж байна. Эрчим хүчний үнэ өсөх нь үйлчилгээ, худалдан авалтын хэмжээг бууруулдаг.

АНУ-ын хөрөнгө оруулалтын банк Wells Fargo 2022 оны Европын ДНБ-ний өсөлтийг дайн, эрчим хүчний үнэ өсөж байгаа нөхцөл байдалтай уялдуулан 4%-иас 3.3% болгон бууруулжээ. Мөн инфляцын түвшнийг 5.2% хувь байхаар төсөөлсөн байна.

Европ даяарх ДНБ өсөлт
/хувиар/



Европ даяарх инфляцын
түвшин



Эх сурвалж: www.edwardjones.com